



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2022 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1,б дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан нийт 117,539,977,925.75 (нэг зуун арван долоон тэрбум таван зуун гучин есөн сая есөн зуун далан долоон мянга есөн зуун хорин таван төгрөг далан таван мөнгө) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу аймаг, нийслэлийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, аймаг, нийслэлийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020-2021 онуудад барьж ашиглалтад оруулсан авто зам, замын байгууламж орон нутагт бий болсон хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, хөрөнгийг капиталжуулж бүртгэх, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан шийдвэрлүүлэх.

2.2.Хөрөнгийг зохих хууль, тогтоомж, журмын дагуу эзэмшигч байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д оруулан бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001117

Төрийн өмчийн бодлого,  
зохицуулалтын газрын 2022 оны 01  
дүгээр сарын 10-ны өдрийн 06  
дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН, ОРОН НУТГИЙН ӨМЧИД  
БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Барилга байгууламж /хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ/-ний нэр	Ашигла лтад орсон он	хөрөнгийн үнэ (төгрөг)	Хүлээн авч бүртгэх аймаг, нийслэл (ОНӨГазар)
1	Хануйн голын төмөр бетон гүүр /Архангай, Эрдэнэмандал сум/	2021	3,498,330,213.00	Архангай аймаг (ОНӨГ)
2	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 2.4 км /Баян-Өлгий, Ногооннуур сум/	2021	2,018,329,535.00	Баян-өлгий аймаг (ОНӨГ)
3	Сумын төвийн хатуу хучилттай зам, 2 км /Баян-Өлгий, Сагсай сум/	2021	1,851,464,228.00	Баян-өлгий аймаг (ОНӨГ)
4	Өлзийт голын төмөр бетон гүүр /Баянхонгор, Галуут сум, 3 дугаар баг/	2020	2,978,104,731.00	Баянхонгор аймаг (ОНӨГ)
5	Аймгийн төвийн авто замын их засвар, шинэчлэл /Дархан-Уул, Дархан сум, 4, 5, 8, 9, Өргөө баг/	2021	1,896,740,401.00	Дархан-уул аймаг (ОНӨГ)
6	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 2.8 км /Дундговь, Сайнцагаан сум/	2021	2,170,858,848.00	Дундговь аймаг (ОНӨГ)
7	Онги голын төмөр бетон гүүр, 54.8 у/м /Дундговь, Сайхан-Овоо сум/	2021	1,507,758,021.00	Дундговь аймаг (ОНӨГ)
8	Өлзийт хороолол чиглэлийн авто зам дахь "МТ" шатахуун түгээх станцын уулзвараас 14 дүгээр хорооны байр, 167 дугаар цэцэрлэг хүртэлх хатуу хучилттай авто зам /Улаанбаатар хот, ХУД 14-р хороо/	2021	2,691,406,868.00	Нийслэл (НӨАУГ)
9	Авто замчдын гудамжнаас Монполимет комплекс орон сууц хүртэлх авто зам /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо/-ын ажлын гүйцэтгэл № 2	2020	474,013,971.00	Нийслэл (НӨАУГ)
10	Дүүргийн доторх авто зам, явган хүний зам /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2021	1,628,640,200.00	Нийслэл (НӨАУГ)
11	Хорооллын доторх авто замын засвар, шинэчлэл /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 12 дугаар хороо, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 24, 25, 26, 27, 28 дугаар байр/	2021	535,945,913.00	Нийслэл (НӨАУГ)
12	Хороодын явган зам, авто зам, нийтийн талбайн ногоон байгууламж, тохижилт /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 6, 15, 18, 25, 26 дугаар хороо/	2021	1,266,803,281.10	Нийслэл (НӨАУГ)
13	Шар хоолойн хатуу хучилттай авто зам, 4.7 км /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо, Гачуурт тосгон/	2021	4,327,187,874.00	Нийслэл (НӨАУГ)
14	Баруун салааны автобусны эцсийн буудлаас Бумбатын рашаан чиглэлийн хатуу хучилттай авто зам, 3.61 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 24 дүгээр хороо/	2021	3,500,941,185.00	Нийслэл (НӨАУГ)

15	Баянбулагийн 2 дугаар гудамжнаас Мандал овооны 3 дугаар гудамж хүртэлх хатуу хучилттай авто зам, 1.5 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2021	1,390,653,000.00	Нийслэл (НӨАУГ)
16	Нарангийн 17 дугаар гудамжнаас 4 дүгээр хорооны Туулын 3 дугаар гудамж хүртэлх авто зам, 1 км /Улаанбаатар, Налайх дүүрэг, 3 дугаар хороо/	2021	1,389,531,355.00	Нийслэл (НӨАУГ)
17	Хорооллын доторх авто замын засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 7, 8, 10 дугаар хороо/	2021	184,931,011.00	Нийслэл (НӨАУГ)
18	Хувьсгалчдын гудамжнаас 105 дугаар сургууль, Гүнжийн нуурыг дайраад 7 дугаар хорооны авто зам хүртэлх авто зам, 1.7 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2021	2,277,777,772.00	Нийслэл (НӨАУГ)
19	Туул голын Сонгинын төмөр бетон 205.1 у/м гүүрийн 2 талын авто зам, нэмэлт ажлууд /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо/	2021	2,281,676,331.00	Нийслэл (НӨАУГ)
20	Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт хэрэгжүүлэх авто замын төсөл, арга хэмжээ /Улаанбаатар хот, Баянгол дүүрэг/ Багц 4	2021	3,497,754,919.00	Нийслэл (НӨАУГ)
21	Улаанчулуутын автобусны эцсийн буудлаас Алтан овоо, Алтан овооноос Буяны замын төгсгөл хүртэлх хатуу хучилттай авто зам, 4 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 26 дугаар хороо/	2021	3,554,675,343.00	Нийслэл (НӨАУГ)
22	Хорооны хатуу хучилттай авто зам/Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо/	2020	432,157,001.00	Нийслэл (НӨАУГ)
23	Сурагчийн 49 дүгээр гудамжны авто зам /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2021	689,100,882.00	Нийслэл (НӨАУГ)
24	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам /Орхон, Баян-Өндөр сум, Баянбулаг, Булаг, Даваат, Наран, Рашаант, Цагаанчулуут баг/	2021	1,999,336,479.00	Орхон аймаг (ОНӨГ)
25	Шинэ суурьшлын бүсийн авто замын өргөтгөл, шинэчлэл /Өвөрхангай, Арвайхээр сум/	2020	1,499,572,510.00	Өвөрхангай аймгийн (ОНӨГ)
26	Орхон голын Онгоцтойн амны төмөр бетон гүүр, 220 у/м /Өвөрхангай, Бат-Өлзий сум/	2021	8,628,923,116.00	Өвөрхангай аймгийн (ОНӨГ)
27	Авто замын уулзварын гэрлэн дохио /Сүхбаатар, Баруун-Урт сум/	2021	798,842,950.00	Сүхбаатар аймаг (ОНӨГ)
28	Сумын төвийн доторх авто зам, тохижилт /Сэлэнгэ, Мандал сум/	2020	3,846,711,539.00	Сэлэнгэ аймаг (ОНӨГ)
29	Хүдэрийн замаас Ерөө сум хүртэлх хатуу хучилттай авто зам, 3.7 км /Сэлэнгэ, Ерөө сум/	2021	2,353,890,869.00	Сэлэнгэ аймаг (ОНӨГ)
30	Зуунмод-Манзушир чиглэлийн хатуу хучилттай авто зам, 7.0 км /Төв, Зуунмод сум/	2021	6,279,477,524.00	Төв аймаг (ОНӨГ)

31	Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны Туул тосгоны хатуу хучилттай авто замын төгсгөлөөс Төв аймгийн Алтанбулаг сумын төв хүртэлх хатуу хучилттай авто зам, 13.7 км /Төв, Алтанбулаг сум/	2020	10,506,000,000.00	Төв аймаг (ОНӨГ)
32	Увс аймгийн Давст сумын Торхилогийн голын төмөр бетон гүүр	2021	1,444,049,871.00	Увс аймаг (ОНӨГ)
33	Сумын төвөөс Хархираа баг хүртэлх сайжруулсан шороон зам, 25 км /Увс, Тариалан сум/	2021	194,696,506.40	Увс аймаг (ОНӨГ)
34	Мянганы босоо тэнхлэгийн замтай сумын төвийг холбох цементэн хучилттай авто зам, 0.95 км /Ховд, Мянгад сум/	2021	275,595,293.00	Ховд аймаг (ОНӨГ)
35	Нүүдлийн авто замын засвар арчлалт /Ховд/	2021	115,544,319.00	Ховд аймаг (ОНӨГ)
36	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 4.6 км /Ховд, Цэцэг сум/	2020	3,288,271,701.00	Ховд аймаг (ОНӨГ)
37	Жаргалант-Галтын авто зам засвар /Хөвсгөл, Жаргалант, Галт сум/	2021	98,698,871.00	Хөвсгөл аймаг (ОНӨГ)
38	Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Үүрийн голын 326 у/м ган-төмөр бетон гүүр	2021	7,822,140,257.25	Хөвсгөл аймаг (ОНӨГ)
39	Аялал жуулчлалын босоо тэнхлэгийн зам, Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн авто замаас Хөвсгөл аймгийн Жаргалант сум хүртэлх хайрган хучилттай авто зам, 27 км /Завхан, Их-Уул сум, Хөвсгөл, Жаргалант сум/	2021	5,254,422,733.00	Хөвсгөл аймаг (ОНӨГ)
40	Онон голын төмөр бетон гүүр, 209.0 у/м /Хэнтий, Биндэр сум/	2021	6,346,682,747.00	Хэнтий аймаг (ОНӨГ)
41	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 2 км /Хэнтий, Мөрөн сум/	2021	1,967,915,836.00	Хэнтий аймаг (ОНӨГ)
42	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам /Хэнтий, Хэрлэн сум/	2020	8,774,421,921.00	Хэнтий аймаг (ОНӨГ)
			117,539,977,925.75	
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		117,539,977,925.75 (нэг зуун арван долоон тэрбум таван зуун гучин есөн сая есөн зуун далан долоон мянга есөн зуун хорин таван төгрөг далан таван мөнгө)	